

Засгийн газрын санхүүгийн статистикийн тухай (Government Financial Statistics)

Нэг. Засгийн газрын Санхүүгийн статистикийн тухай

Зах зээлийн эдийн засагт үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хоорондын арилжаа зонхилж, Засгийн газрын эдийн засгийн үйл ажиллагаа онцгой шинжтэй байдаг. Жишээ нь: Засгийн газрын төсвөөс санхүүждэг үйлчилгээнүүд зах зээлийн үнээр тооцогддоггүй. Ийм учраас Үндэсний Тооцооны Систем болон Олон Улсын Валютын Сангаас гаргасан Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн цаашид ЗГССГ гэх\- Гарын Авлагад Засгийн газрын секторын бүтээгдэхүүнийг орцын нь өртгөөр тооцохыг зөвлөсөн байдаг. Гэхдээ орцын өртөг нь тэр орцыг хамгийн ашигтай өөр нэг зориулалтаар хэрэглэхэд олж болох орлогоор тодорхойлогдох учир тойруу замаараа зах зээлийн үнэлгээг тусгаж байдаг. Өнөөдөр дэлхийн улс орнуудын ихэнхи хэсэг 1986 онд боловсруулж гаргасан ЗГСС-ийн гарын авлага болон мөн зарим улс орнууд 2001 оны ЗГСС-ийн гарын авлагыг тус тус ашиглаж байна. Төсвийн зохицуулалтын зорилго нь олон байдаг учраас түүнийг үнэлэх арга зам нь мөн олон байна. Төсвийн зохицуулалт нь хичнээн сайн зохион байгуулалттай байсан ч гэсэн төсвийн үзүүлэлтүүдийг буруу, дутагдалтай гардаг бол амжилтанд хүрэхгүй. Ялгаатай асуудлууд, зорилтууд болон эдийн засгийн бүтэц нь бүх нөхцөл байдалд тохирох дан ганц хэмжилтийн суурь болдоггүй. Улс орнуудын туршлага эдгээр олон төрлийн хэмжүүр үзүүлэлтүүдэд нөлөөлсөөр байгаа бөгөөд үүний үр дүнд олон улсын статистикийн стандарт шинэчлэгдэн өөрчлөгдсөөр, улс орнууд *Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлага 2001¹* -г мөрдөж эхэлж байна.

1. ¹ Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлага-2001 нь Засгийн газрын санхүүгийн статистикийн зарчим, тодорхойлолт, ангилал, ба нягтлан бодох бүртгэлийн дүрмийн талаарх лавлагаа материал бөгөөд шинжилгээ, төлөвлөгөө, ба бодлогын зорилгоор нэгтгэж, толилуулахад зохистой төсвийн нэгтгэлд орох тоон өгөгдөлүүдийн хүрээг тогтоосон байдаг.

Хоёр. ЗГССГА 2001: ЗГССГА 1986-аас ялгаатай үндсэн ялгаанууд

Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлага-2001 (ЗГССГА-2001) нь ЗГССГА 1986-аас гурван гол өөрчлөлтөөр ялгаатай.

- **Аккруэл суурь.** ЗГССГА 1986-аас өөрчлөгдсөн гол ялгаа нь төсвийн статистикийг аккруэл сууриар буюу мөнгө төлсөн буюу хүлээн авсан үед биш харин эдийн засгийн үйл явдал гарсан үед нь бүртгэхээр болсон.
- **Үлдэгдэл болон гүйлгээний нэгтгэл.** ЗГССГА 2001-н гол суурь тулгуур нь гүйлгээ, үлдэгдэлийн хоорондын сайн тодорхойлогдсон харилцаа болно. Тодруулбал Засгийн газрын эхний болон эцсийн үлдэгдэл тайлан нь Засгийн газрын үйл ажиллагаа болон эдийн засгийн бусад гүйлгээ (байгалийн гамшгийн улмаас бий болсон хөрөнгийн эвдрэл, гэмтлийн улмаас хийгдсэн үнэлгээний өөрчлөлт зэрэг)-тэй тохируулагдаж байна.
- **Аналитик хүрээ.** Энэ нь гурван гол хүснэгт, дөрвөн гол балансаас бүрдэнэ.
 - ***Засгийн газрын үйл ажиллагааны тайланд*** ажил гүйлгээг дараах байдлаар ангилан толилуулна: (1) орлого, зардал зэрэг цэвэр хөрөнгөнд нөлөөлдөг ажил гүйлгээ; (2) санхүүгийн бус хөрөнгө; (3) санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр. Орлого ба зардлын зөрүүг *цэвэр үйл ажиллагааны тэнцэл* (ЗГССГА 1986-д урсгал тэнцэл гэдэг байсан) гэнэ. Үүнээс санхүүгийн бус хөрөнгийн цэвэр худалдан авалтыг хасвал *цэвэр зээллэг/зээлийн тэнцэл* (ЗГССГА 1986-д нийт тэнцэл гэдэг байсан, ялгаатай одоо цэвэр зээллэгийг оруулдаггүй болсон) гарах ба энэ нь нөгөө талаас санхүүгийн хөрөнгийн цэвэр худалдан авалтаас цэвэр өр төлбөрийн дүнг хассантай тэнцүү.
 - ***Үлдэгдэл тайлан*** нь тайлант хугацааны эцэс дэх Засгийн газрын *цэвэр хөрөнгийн* дүнг харуулах ба санхүүгийн бус хөрөнгийн үлдэгдэл дээр санхүүгийн цэвэр хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн үлдэгдлээс өр төлбөрийг хассан) нэмсэнтэй тэнцүү. Тухайн жилд гарсан цэвэр хөрөнгийн өөрчлөлт нь

орлого ба зардлын ажил гүйлгээ, эдийн засгийн бусад гүйлгээний улмаас гарсан өөрчлөлтүүдийн нийлбэр юм.

- **Нөөцийн ба мөнгөний ашиглалтын тайлан** нь мөнгөн ашиг/алдагдлын тооцоонд ордог орлого, зардлын ажил гүйлгээ ба санхүүгийн бус хөрөнгийн ажил гүйлгээний цэвэр мөнгөн гүйлгээг харуулна. Санхүүгийн хөрөнгө (мөнгөн хөрөнгөөс бусад хөрөнгө) ба өр төлбөрийн мөнгөн гүйлгээн дээр мөнгөн ашиг/алдагдлыг нэмсэнээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийн цэвэр өөрчлөлт гарна.

ЗГССГА 2001-г бүрэн хэрэгжүүлэх ажиллагаа нилээд олон улс оронд эхлээд байгаа бөгөөд энэ ажлын үр дүн нь шинэ хүрээгээр төсвийн тоо, мэдээг богино хугацаанд толилуулах боломжтой болсноор илрэх болно.

Гурав. ЗГССГА: Засгийн газрын тодорхойлолт

ЗГСС-ийн гарын авлагад Засгийн газрын үүргийг “бусад сектороос татвар авч зах зээлийн бус үйлчилгээ хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байдаг. Засгийн газрын сектор нь дээрх үүргийг хэрэгжүүлж байгаа бүх нэгжийг хамаарах ба дотроо а) эрх мэдэл нь тухайн орны нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан төв Засгийн газар, б) тодорхой хэсэг нутагт эрх мэдлээ бие даан хэрэгжүүлж байгаа штат, муж, в) газар нутгийн нэгжүүдийн түвшинд төрийн үүргийг хэрэгжүүлж байгаа орон нутгийн захиргаа, г) татвар төсвийн зарлагатай холбогдолтой үүрэг бүхий олон улсын байгууллага гэж хуваагдана.

Нийгмийн даатгалын санд болон хэвлэх үйлдвэр зэрэг яам газрын шууд харьяа аж ахуйн газрууд нь Засгийн газрын аль нэг түвшинд хамрагдана. Харин улсын үйлдвэрүүд хамрагдахгүй. Улсын өмчийн буюу улсын шууд хяналтад байдаг боловч бүтээгдэхүүн үйлчилгээгээ зах зээл дээр худалддаг бүх нэгжийг санхүүгийн бус үйлдвэрийн секторын улсын хэсэгт оруулж тооцно. Хадгаламж авч, зээл олгох, санхүүгийн хөрөнгөөр арилжаа хийх зэрэг санхүүгийн үйл ажиллагаа

явуулдаг улсын өмчийн буюу хөнгөлөлтийн байгууллагуудыг санхүүгийн байгууллагын секторын улсын хэсэгт хамруулна. Энэ секторт Төв банк багтдаг.

3.1 Засгийн газрын арилжааг хэмжиж тооцох нь

ОУВСангийн журамд ЗГСС-ийг бэлэн мөнгөний зарчмаар буюу төлбөр хийгдсэн цагаар нь орлого зарлагыг бүртгэдэг. Энэ зарчим нь Засгийн газар ба эдийн засгийн бусад секторын хоорондын хөрөнгийн урсгал хөдөлгөөнийг нэлээд бодитой тусган харуулах боломж олгохын зэрэгцээ санхүүгийн бусад статистиктай нягт уялдуулж өгдөг.

Хэрэв Засгийн газар өөрийн үнэт цаасыг хэрэглэн арилжаа явуулбал орлого зарлагын талыг тус тусад нь бүртгэдэг Жишээлбэл, Засгийн газар урт хугацааны бонд гаргаж тодорхой арилжааг санхүүжүүлсэн бол түүнийг зарлагад, бонд гаргалтыг зээл гэж бүртгэнэ. Засгийн газрын орлого зарлагаас эдийн засагт үзүүлэх бүхий л нөлөөллийг харуулахын тулд тэднийг цэвэр бус нийт дүнгээр статистикт тусгана. Тухайлбал, татвар хураахтай холбогдон гарч байгаа зардлыг татварын дүнгээс хасахгүйгээр тус тусад нь бүртгэдэг. Сургалтын төлбөрийг мөн энэ шалтгааны улмаас сургуулиудын санхүүжилтээс хасдаггүй. Яамдын шууд харьяа газруудын хувьд зөвхөн ашиг буюу алдагдал, өөрөөр хэлбэл цэвэр дүн л Засгийн газрын хөрөнгөнд нөлөөлнө. Харин эдгээр газрын хөрөнгийн холбогдолтой арилжааг Засгийн газрын санхүүгийн тооцоонд нийт дүнгээр тусгадаг.

Засгийн газрын дотоод нэгжүүдийн хоорондын арилжааг нэгтгэн нийт Засгийн газрын сектороос эдийн засгийн бусад сектортэй хийж байгаа арилжааны дүнг гаргана. Ялангуяа төв Засгийн газрын тооцоог онцгой чухалчилж үздэг. Учир нь энэ бол төсвийн бодлогын үүднээс хамгийн чухал ангилал төдийгүй статистик бүртгэл нь харьцангуй богино хугацаатай дэлгэрэнгүй хөтлөгдөж хурдан бэлэн болдог.

3.2 Засгийн газрын арилжааны үйл ажиллагааны ангилал

Засгийн газрын арилжаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа нь орлого, тусламж, зарлага, цэвэр зээл, санхүүжилт гэсэн гол ангилалд хуваагддаг.

3.2.1 Ерөнхий зүйлүүд

Бараа, үйлчилгээ, өмчийн эрх зэрэг тодорхой үнэ цэнэтэй зүйлийн оронд төлж байгаа төлбөрийг хариу төлбөртэй, тусламж, татвар зэрэг хариуд нь юу ч авахгүй төлбөрийг хариу төлбөргүй арилжаа гэж ялгана. Нэгээс илүү жилийн настай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг, хөрөнгө баялгийн өнөөгийн дүн ба ирээдүйн орлогод нөлөөтэй барааг капитал бараа бусад зүйлсийг урсгал бараа гэдэг.

Санхүүгийн актив, пассив улсын төсвийн хувьд харилцан адилгүй нөлөөтэй. Жишээлбэл, Засгийн газар зээл авах нь санхүүжилтийн шаардлагаас үүдсэн байдаг бол зээл олгох нь гол төлөв тодорхой бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн байдаг. Үүнд, Тусгайлан дэмжих шаардлагатай гэж үзсэн аливаа бүлэгт хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох нь бодлогын илрэл юм. Харин тусгай нөөцийн буюу нийгмийн даатгалын зарим систем зэрэг үндсэндээ санхүүжилтийн шаардлагаар улс авлагатай болох тохиолдол бий. Энэ хоёр тохиолдолын алинд ч Засгийн газар эдийн засгийн бусад хэсгээс авлага үүсч байгаа боловч тэдгээрийн учир шалтгаан зорилго эрс өөр юм. Энэ зарчмын ялгаанаас үүдэн санхүүжилтийн зориулалтаар гаргасан авлага Засгийн газрын пассивт оруулан тусгадаг. Нэгэнт тооцоог бэлэн мөнгөний зарчмаар хөтөлдөг тул Засгийн газрын мөнгөний балансын өөрчлөлт нь тухайн хугацааны орлого, төлбөрийн нийлбэртэй тэнцэнэ.

3.2.2 Улсын төсвийн орлого буюу Засгийн газрын Орлого.

Засгийн газрын орлого нь гадаад улс, олон улсын байгууллагын тусламжаас бусад эргэж төлөх нөхцөлтэй, нөхцөлгүй бүх орлогоос бүрдэх бөгөөд дотроо урсгал, хөрөнгийн орлогод хуваагдана. Урсгал орлогод бүх татвар ба татварын

бус урсгал орлого, хөрөнгийн орлогод хөрөнгө зарсантай холбогдсон орлого багтана.

Татварыг Засгийн газраас улсын бодлого явуулах зорилгоор тогтоосон, заавал төлөх, эргэж төлөх нөхцөлгүй \буцалтгүй\ хандив гэж тодорхойлдог ба түүнд заавал төлөх ёстой нийгмийн даатгал болон улсын монополиудаас төсөвт оруулсан ашгийг мөн хамааруулна. Шуудан холбооны систем зэрэг монопол бол үндсэндээ тухайн үйлчилгээ бүтээгдэхүүнийг монополчилсон борлуулах замаар төсөвт орлого оруулах хэлбэр юм.

ЗГСС-ийн гарын авлагад татварыг төлөх суурь буюу орлого бий болгож байгаа үйл ажиллагааны төрлөөр нь үндсэн долоон ангилалд хуваан үздэг. Татварын бус орлогод хөрөнгийн орлого, төлөөс, аж үйлдвэрийн бус борлуулалт, яам газрын дотоод аж ахуйн нэгжийн ашиг, мөн төрөөс ногдуулах торгууль зэрэг багтана. Хөрөнгийн орлогод үндсэн хөрөнгө, нөөц, газар болон биет бус хөрөнгө худалдаанаас орох орлогууд багтана.

3.2.3 Засгийн газрын тусламж буюу Гадаадын буцалтгүй тусламж

Тусламжийг гадаад орны Засгийн газар, олон улсын байгууллагаас өгсөн эргэж төлөх нөхцөлгүй, заавал бус шинжтэй орлого гэж тодорхойлдог ба төсвийн балансыг тооцоолоход түүнийг орлоготой хамтруулан авч үздэг тул тусламж нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэхгүйгээр багасгана.

3.2.4 Засгийн газрын зарлага буюу Улсын төсвийн зарлага

Улсын төсвийн зарлагад Засгийн газрын эргэж төлөх нөхцөлтэй болон нөхцөлгүй, урсгал буюу хөрөнгийн, буцааж төлөхгүй бүх зардал хамаарах ба бусдад тухайлбал доод шатанд өгч байгаа тусламж мөн төв Засгийн газрын зарлагад орно.

Засгийн газрын болон нийт эдийн засгийн тооцоонд зарлагын зарим ангилал онцлог ач холбогдолтой. Жишээ нь, зөвхөн эргэж төлөх нөхцөлтэй зарлага л ҮТС-ийн хэрэглээ, хөрөнгийн хуримтлал, бүтээгдэхүүнд нөлөөлнө. Мөн урсгал ба хөрөнгийн зарлагын ялгаа нь Засгийн газрын хэмнэлтийг тооцох үндэс болно.

Хөрөнгийн зарлагад нэг жилээс илүү настай, тодорхой хэмжээнээс доошгүй үнэтэй хөрөнгө, нөөц газар, биет бус хөрөнгө худалдан авах, хөрөнгө шилжүүлэхэд гарсан зардал орно. Засгийн газрын бус нэгж, тухайлбал улсын үйлдвэрийн газар үндсэн хөрөнгө худалдаж авсан бол төсвийн ангиллаар цэвэр зээлд оруулж тооцно.

3.2.5 Засгийн газрын Цэвэр зээл буюу Улсын төсвийн цэвэр зээл

Олгосон зээлээс төлөгдсөн зээлийг хасаад үлдэж байгаа цэвэр зээл нь Засгийн газрын санхүүжилтийг хангах буюу орлого олох зорилгоор бус, харин улсын тодорхой бодлого хэрэгжүүлэх үүднээс хийсэн арилжааны дүнд бусдаас авах болсон авлага бөгөөд зээл буюу хувьцаа эзэмшлийн хэлбэртэй байж болно. Харин засгийн газрын мөнгөн хадгаламж, бэлэн мөнгөний өөрчлөлт нь цэвэр зээлд бус санхүүжилтэд багтана.

ЗГСС-ийн гарын авлагад төсвийн балансыг тооцоолохдоо цэвэр зээлийг зарлагатай хамт авч үздэг, өөрөөр хэлбэл Засгийн газар авч байгаа зээлийн санхүүжилтэнд оруулдаггүй. Энэ бол Засгийн газар зээл авах, зээл өгөхийн цаад зорилго зарчмын ялгаатай байдгийн илрэл юм.

3.2.6 Засгийн газрын санхүүжилт буюу улсын төсвийн санхүүжилт

Тооцоо бүртгэлийн утгаараа бол нийт орлого\ авсан зээлийг оролцуулан\ ба бэлэн мөнгөний зарлага нь нийт төлбөр \зээлийн төлбөрийг оруулан\ ба бэлэн мөнгөний хуримтлалтай ямагт тэнцэж байдаг. Тэгэхдээ дүн шинжилгээний үүднээс арилжааны зарим төрлийг төсвийн балансыг тодорхойлогч хүчин зүйл,

А.Энхбат-Засгийн газрын санхүүгийн статистикийн тухай (GFS)

заримыг нь орлого зарлагын зөрүүг санхүүжүүлэхэд чиглэсэн арилжаа гэж ялгаж болох бөгөөд ЗГСС-ын гарын авлагад доорхи тодорхойлолтыг баримталдаг. Үүнд:

Төсвийн алдагдал буюу илүүдэл = (Орлого+Тусламж) - (Зарлага+Цэвэр зээл)

Энэ томъёололыг дараах байдлаар өөрчлөн бичиж бас болно. Үүнд:

Нийт алдагдал буюу илүүдэл=санхүүжилт = \зээл- Зээлийн төлбөр\ - бэлэн мөнгөний цэвэр өсөлт

Засгийн газраас мөнгө гаргах, хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд тооцогдох ба эдгээр үйл ажиллагаанаас төсөвт орох хөрөнгийг санхүүгийн сектороос орсонд тооцож цэвэр дүнгээр бүртгэнэ.

3.2.7 Засгийн газрын нийт өр буюу улсын төсвийн дотоод гадаад өр

Засгийн газрын өр гэдэг бол урьд авсан зээлийн төлбөрт эдийн засгийн бусад хэсэг буюу дотоодод болон гадаадад төлөх ёстой, албан ёсоор хүлээн зөвшөөрсөн бөгөөд тодорхой хугацаанд төлж арилгах буюу байнга үргэлжлэх шинжтэй байж болно. Эдийн засгийн гол салбаруудын тооцооны хаилцан уялдааны үүднээс бол ЗГСС-т тусгагдсан, өөрөөр хэлбэл төв буюу ерөнхий Засгийн газрын өр л дүн шинжилгээний ач холбогдолтой байдаг.

3.3 Төсвийн үйл ажиллагааг урьдчилан тооцох арга зүй

Улсын төсөв эдийн засаг дахь нийт зарлага бүтээгдэхүүний хэмжээнд чухал нөлөө үзүүлж байдаг. Эдийн засагт үүсч байгаа нийт эрэлтийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь улсаас авч байгаа бараа, үйлчилгээний зардал юм. Мөн

татвар, орлого шилжүүлэлтийн бодлого хувийн секторын хэрэглээнд нөлөөлнө. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх арга хэлбэр ч инфляци, дотоодын хүүгийн түвшинд нөлөөлөх бөгөөд мөнгөний гол үзүүлэлттэй шууд холбоотой байдаг. Олон тохиолдолд макро эдийн засгийн тэнцвэр алдагдсаны гол шалтгаан нь төсөвтэй холбоотой байдаг ба түүнийг засахад төсвийн орлого, зарлага буюу санхүүжилтийн талаар зохих арга хэмжээ авах шаардлагатай болдог.

3.3.1 Орлого ба тусламжийг тооцох нь

Татварын орлого: Татварын хэмжээг урьдчилан тооцоход татварын суурь ба түвшин цаашид яаж өөрчлөгдөх нь вэ гэдгийг ялгаж үзэх шаардлагатай. Татварын суурь гэдэг нь тухайн төрлийн татварын хэмжээ буюу үнэлгээгээр илэрхийлэгдэнэ. Орлогын, импортын гэсэн ангилал нь татварын суурийн жишээ юм. Татварыг түүний суурийн шинж чанарыг баримтлан ангилах бөгөөд зарчмын хувьд татвар бүрийг хуулиар тодорхой суурьт хамруулж болдог. Гэхдээ татварын хуулинд татварын суурийг өөрөөр тодорхойлох нь бий. Татварын түвшин тухайн суурь дотроо өөр өөр байж болохын зэрэгцээ зарим тохиолдолд татвараас чөлөөлсөн ч байдаг. Хуулиар тогтоосон татварын суурь яаж өөрчлөгдөх талаар нарийн мэдээлэл байхгүй нөхцөлд урьдчилсан тооцоонд ойролцоолсон суурийг ашиглаж болно. Жишээлбэл, импортын татварын орлогыг тооцоход төлбөрийн балансыг тооцоолох явцад гаргасан импортын урьдчилсан дүнг ашиглаж болно.

Тохиромжтой ангиллыг тогтоосны дараа татварын суурь бүрийг тэр төрлийн татварын хэмжээтэй холбосон функц байгуулах замаар татварын орлогын урьдчилсан тооцоо гаргана. Нийт татварыг хир жижигрүүлж ангилах нь мэдээллийн хангамжаас шалтгаалах боловч татварын гол төрлүүдэд хуваахыг хичээх хэрэгтэй. Ялангуяа их хэмжээний орлоготой, суурь нь эрс ялгаатай татваруудыг тусгайлан ангилж үзэх нь чухал.

Зарчмын хувьд татварын түвшин суурийн эргэх холбоог орлогын тооцоонд мөн анхаарах ёстой. Үүнд автомашинаас хураах гаалийн татварыг нэмэгдүүлэхэд худалдан авч байгаа машины тоо цөөрч улмаар тэр татвар буурна. Эдийн засгийн

бүх секторын уялдааг тусгасан макро загвар бүтээх замаар иймэрхүү эргэх холбоог тусгаж болох юм.

Орлогын өсөлт нь зориудын буюу аяндаа бий болох шинжтэй байж болно. Импорт өссөний дагуу импортын татвар нэмэгдэх зэрэг татварын суурь өссөний улмаас орлого өсч байгаа нь аяндаа тохиолдож байгаа өсөлтийн жишээ юм.

Татварын хувийг өөрчлөх шинэ татвар бий болгох, татварын хамрах хүрээх тэлэх, татвар цуглуулалтыг сайжруулах зэргээр татварын системд нөлөөлөн орлогыг өсгөх нь зориудын өсөлтийн жишээ болно.. Энэ хоёр төрлийн ялгааг ойлгох нь орлогын төлөвийг шинжлэхэд чухал үүрэгтэй.

Дээрхтэй шууд холбоотой хоёр ойлголт бол эдийн засаг дахь үйл явц орлогод яаж нөлөөлж байгааг илэрхийлдэг, татварын өсөх чадвар ба мэдрэмж юм. Татвар цуглуулалтын өөрчлөлтийн хувийг ДНБ-ний өөрчлөлтийн хувьд харьцуулсныг татварын өсөх чадвар гэх ба энэ үзүүлэлт нэгээс их буюу бага байвал татварын өсөлт ДНБ-ийн өсөлтөөс илүү буюу дутуу байна гэсэн үг юм. Татварын мэдрэмж нь татварын өсөлтийг тухайн хугацаанд татварын систем өөрчлөгдөхгүй гэсэн үндсэн дээр ДНБ-ний өсөлттэй харьцуулдаг ба утга нь дээр өгүүлсэн татварын өсөх чадварын үзүүлэлттэй яг адил боловч зөвхөн аяндаа бий болох өсөлтийг илэрхийлдгээрээ ялгаатай. Үүнд, мэдрэмж нэгтэй тэнцүү байвал тухайн татварын системийн нөхцөлд орлого ДНБ-тэй адил хурдаар өснө гэсэн юм.

Татварын бус орлого: Татварын бус орлогод хөрөнгийн орлого, төлбөр төлөөс, торгууль, аж үйлдвэрийн бус борлуулалт, яам газрын дотоодын үйлдвэрийн ашиг (түүний дотор Төв банкны ашиг) орно. Тэдгээрийн зарим нь тогтвортой хамааралтай байж болох боловч олонхи тохиолдолд тогтворгүй байдаг. Иймд тэдгээрийг ДНБ-тэй харьцуулах буюу өөрийн нь хандлагыг харгалзах үндсэн дээр тооцдог болно.

Тусламж: Төсөвт тусах тусламжийн хэмжээг хандивлагчдын өгөх тусламжийн тухай албан ёсны тохиролцоонд үндэслэн гаргана. Энэ тоо төлбөрийн баланс дахь хариугүй шилжүүлэлттэй мөн таарч байх ёстой.


Тусламжийг урьдчилан тооцоход амласан цаг хугацаандаа олгогдохгүй байх хандлага бас байдгийг харгалзах шаардлагатай.

3.3.2 Зарлага, цэвэр зээлийг тооцох нь

Төсвийн зарлагын зарим гол төрлүүд яаж өөрчлөгдөх нь эдийн засгийн бусад үзүүлэлттэй шууд холбоотой. Улсын секторын цалингийн өсөлт гэхэд төрийн албаны цалингийн талаар, ялангуяа инфляцтай индексчлэхтэй холбогдуулан явуулж байгаа бодлого, хувийн секторын цалингийн түвшингээс шалтгаалдаг.

Төсвөөс санхүүжих бараа үйлчилгээний зардал үнийн түвшинг дагаж өсөх боловч төсөв зарцуулах журмаас шалтгаалан өсөлт их бага байж болно. Төсвөөс төлөх хүүгийн төлбөр нь дотоод гадаадын хүүгийн түвшин, Засгийн газрын гадаад дотоод өрийн хэмжээнээс шалтгаална. Зарим шилжүүлэх төлбөрийг мөн тооцоолж болно. Жишээлбэл, ажилгүйдлийн тэтгэмж эдийн засгийн байдалтай, өндөр насны тэтгэвэр хүн ам зүйн өөрчлөлттэй холбоотой. Зарим орны тухайд хөрөнгийн зардал гадаад санхүүжитийн эх үүсвэрээс ихээхэн шалтгаалдаг.

Эцсийн дүнд Засгийн газрын зардал дэвшүүлж байгаа бодлогоос үлэмж хэмжээгээр хамаарах бөгөөд удирдлагын шийдвэрээс шалтгаалан өөрчлөгдөнө. Мөн засгийн газраас тогтоосон нийт зарлагын хязгаарлалт нь орлогын тодорхой зүйл ангийг өсгөх боломжид нөлөөлдөг.



3.3.3 Санхүүжилтийг урьдчилан тооцох нь

Санхүүжилтийг тооцоход гадаад санхүүжилт, банкны бус дотоодын зээл, банкны системээс авах дотоодын зээл гэсэн гурван эх үүсвэрийг авч үздэг. Засгийн газрын гадаад зээл авах төлөвлөгөө, өрийн төлбөр хийх хуваарь нь гадаад санхүүжилтийн тооцоо хийх гол үндэслэл юм. Тэгэхдээ гадаад зээлдүүлэгчдийн байдал, шинэ зээл авах, өр төлөх талаар төлбөрийн балансын капитал тооцоонд тусгагдсан төлөвтэй нягт уялдсан байх шаардлагатай.

Хэрэв гадаад өрийн түвшин (Гадаад Өр/ДНБ) буюу бүтэц хүндрэл учруулахуйц байвал энэ асуудлыг илүү өргөн утгаар авч үзэж тооцоондоо тусгах нь зүйтэй. Банкны бус дотоодын зээлийн тухайд засгийн газраас дотоодын санхүүгийн байгууллагууд болон бусад зээлдүүлэгчдэд өөрийн үнэт цаасыг хэр хэмжээгээр борлуулж чадах вэ гэдгийг цэвэр дүнгээр нь тогтоох шаардлагатай. Үүнтэй уялдуудлан хүүгийн түвшин болон засгийн газрын бус үйл ажиллагаа, ялангуяа хувийн секторын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэрт яаж нөлөөлөхийг анхаарч үзэх хэрэгтэй.

Банкны системээс авах зээлийн цэвэр дүнг санхүүжилтийн үлдэгдлээр гаргах бөгөөд энэ нь дотоодын нийт зээлийн өсөлтийн талаар тавьсан зорилттой тохирч байх хэрэгтэй.

3.3.4 Төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тухай

Төсвийн байдлыг нийт тэнцэл гэх мэт гүйлгээний үзүүлэлтүүдээр, мөн Засгийн газрын өрийн дүн гэх мэт үлдэгдэл үзүүлэлтүүдээр үнэлэх ёстой.

Төсвийн нийт тэнцэл нь төсвийн үзүүлэлтийн хамгийн нийтлэг хэрэглэгддэг үзүүлэлт юм. Энэ нь нийт орлого (буцалтгүй тусламж орсон) ба нийт зарлагын зөрүүн дээр зээллэгийг нэмж эргэн төлөлтийг хассантай тэнцүү. Нийт тэнцлийн өргөн хүрээтэй хэрэглээ нь түүний Засгийн газрын цэвэр санхүүжилтийн

шаардлага болон гадаад урсгал данснтай уялддаг.²

Тохируулсан төсвийн нийт тэнцэл гэж буцалтгүй тусламж, эсвэл тодорхой онцлог үйл ажиллагаанаас (жишээлбэл, газрын тосны салбар) олсон орлого, эсвэл тодорхой хэсэг бүлэг зарлагын зүйлсийг оруулж тооцоогүй нийт тэнцлийг хэлнэ.

- Гадаадын буцалтгүй тусламж нь нийт орлого ба буцалтгүй тусламжид багтана. Учир нь буцалтгүй тусламж нь өрийн дүнг нэмэгдүүлдэггүй бөгөөд зарлагын дүнг санхүүжүүлдэг. Гэвч буцалтгүй тусламж нь ихэвчлэн хэлбэлзэлтэй, урьдчилан таамаглах боломжгүй, Засгийн газрын хяналтаас гадуур байдаг ба мөн цаашид үргэлжлэхгүй болж болох бөгөөд дотоод эрэлтийг бууруулдаггүй. Тиймээс буцалтгүй тусламж мэдэгдэхүйц өндөр дүнтэй байгаа үед нийт тэнцлийг ихэвчлэн буцалтгүй тусламж орсон болон ороогүй байдлаар аль алингаар бэлтгэж, тайлагнадаг. Буцалтгүй тусламжийг оруулж тооцоогүй тэнцэл нь буцалтгүй тусламжаас хараат бус байдлын хүрээг илэрхийлдэг.
- Буцалтгүй тусламжийн адил газрын тосны орлого нь маш их хэлбэлзэлтэй, урьдчилан таамаглах боломжгүйгээс гадна дахин сэргээгдэхгүй бөгөөд үүнийг ашигласнаар Засгийн газрын баялагийн хэмжээ буурдаг. Газрын тосноос (эсвэл бусад дахин сэргээгдэхгүй нөөц, баялагаас) нилээд хамааралтай улс орнуудын газрын тосны салбарыг оруулж тооцоогүй тэнцэл болон түүний газрын тосны салбарыг оруулж тооцоогүй ДНБ-нд харьцуулсан харьцааг авч үзэх нь түгээмэл байдаг. Хувьчлалын орлогыг үүнтэй ижил шалтгаанаар мөн нийт тэнцэлд оруулж тооцдоггүй.
- Гадаадаас санхүүжүүлж буй төслийн зарлага нь мөн Засгийн газрын хяналтаас гадуур байдаг ба энэ нь импортын томоохон бүрэлдэхүүн хэсэг

² Нарийн уялдаа холбоог гаргах нь нилээд төвөгтэй бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн тодорхойлолтоос хамаарна. Жишээлбэл зээллэгээс эргэн төлбөрийг хассан дүнг “шугамаас дээгүүр” харуулснаар (ЗГССГА 2001-ээс ялгаатай,) нийт тэнцэл нь Засгийн газрын санхүүгийн цэвэр байдалтай тэнцүү биш болно.

А.Энхбат-Засгийн газрын санхүүгийн статистикийн тухай (GFS)

болдог бөгөөд дотоод нийлүүлэлтэд хязгаарлагдмал нөлөө үзүүлдэг ба автоматаар санхүүжигддэг (хэрэв зээллэгээр санхүүжигдэж байвал өрийн дүнг өсгөхгүй). Гадаадын буцалтгүй тусламж, гадаадаас санхүүжүүлж буй төслийн зарлага ба гадаад хүүгийн төлбөрийг оруулж тооцоогүйг *дотоод тэнцэл* (улс орнуудад өөр өөр тодорхойлолт хэрэглэгддэг) гэнэ.

- Орлогоос хүүгийн бус (суурь) зарлагыг хассан *суурь тэнцэл* нь хүүгийн төлбөрийг өмнөх оны алдагдалаас хөөн урьдчилан тооцоолох байдлаар төсвийн “чармайлт”-ыг илэрхийлэх ба энэ нь өрийн тогтвортой байдлын шинжилгээг хийх гол суурь болдог. *Өр-тогтворжуулах суурь тэнцэл* нь өр/ДНБ-ний харьцааг тогтвортой хадгалах суурь тэнцэл юм.
- *Үйл ажиллагааны тэнцэл* (нийт тэнцлээс инфляцийн нөхцөлд эзэмшиж байгаа өрийг барагдуулах өрийн үйлчилгээний хэсгийг хассан)-ийг инфляцийн өндөр түвшинтэй үед бэлтгэж, тайлагнадаг.

Урсгал орлого ба урсгал зарлагын зөрүүгээр тодорхойлогддог *урсгал тэнцэл* нь Засгийн газрын хуримтлалын хэмжээг илэрхийлдэг. Урсгал тэнцэлийн хувьд зорилтот түвшинг тогтоож ажиллах нь төсвийн нэгтгэлийн үе тутамд хөрөнгө оруулалтыг сөрөг нөлөөллөөс хамгаалж, Засгийн газрын цэвэр хөрөнгийн хэмжээг тогтвортой барьж мөн залгамж үеүдэд үлдэх өмчийг нэмэгдүүлдэг ач холбогдолтой. Гэвч урсгал тэнцэлд хэт анхаарал хандуулж ажиллах нь эрсдэлийг бий болгодог (ОУВС, 2004 он):

- Хөрөнгө оруулалт зарлага дээр нийт эрэлтийг нэмэх.
- Санхүүжилт нь хязгаарлагдмал улс орнуудад нийт тэнцлийг тогтвортой байлгахад ашигалах хувилбарууд нь цөөхөн байдаг. Тухайлбал зээлийн үндсэн өрийн төлбөрийн өндөр байгаа нөхцөлд төсвийн зорилтот, боломжит санхүүжилтийн хэмжээг цэвэр дүнгээс илүү нийт дүнгээр тогтоох нь зүйтэй байдаг.

А.Энхбат-Засгийн газрын санхүүгийн статистикийн тухай (GFS)

- Урт хугацааны өрийн тогтвортой байдлыг хангахын тулд зээлийн хэмжээг хязгаарлаж байх ёстой.
- Улсын хөрөнгө оруулалтын төслийн үр өгөөж хангалттай түвшинд хүрч чадахгүй буюу өсөлтөөс хүртэх төсвийн ноогдол ашиг бодитоор хэрэгжихгүй байгаа бол (өөрөөр хэлбэл улсын хөрөнгө оруулалт нь өөрөө өөртөө төлбөр өгдөггүй) өрийн хэмжээ тогтвортой бус болдог.
- Татвар хувь хэмжээ эсвэл хүний нөөц, үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний хөрөнгө оруулалтыг бууруулах нөлөөлдөг улсын бусад сангуудын ашиглалт нь улсын хөрөнгө оруулалтаас илүү үр өгөөжтэй байж болно. Төсвийн зорилтот хэмжээнд улсын хөрөнгө оруулалтыг оруулж тооцохгүй байх нь хөрөнгө оруулалтын сонголтыг авч үзэхгүй орхигдуулах, мөн дэд бүтцийн салбар дахь хувийн салбарын оролцоог ялгаварлан гадуурхах байдлыг бий болгоно.
- Урсгал тэнцэлд хэт анхаарал хандуулж ажилласанаар урсгал зарлагыг хөрөнгийн зарлагаар ангилах бүртгэлийн хандлагыг бий болгож болно.

А.Энхбат
Дэлхийн банкны “Дунд болон богино хугацааны төсвийн
төлөвлөлтийн төсөл”-ийн зөвлөх